



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/97

Арвайхээр

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах
тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Бат-Өлзий сумын 1, 2 дугаар цэцэрлэгүүдийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл тус тус 5 жилийн хугацаатай сунгасугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл сунгагдсан дээрх байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100212